



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/270

Мөрөн сум

Согтууруулах ундааны хариуцлагатай  
үйлчилгээний сургалтын жишиг хөтөлбөр,  
модуль батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2, Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Журам болон жишиг төлбөрийн хэмжээг батлах тухай” 2023 оны А/04 дүгээр тушаал, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Журам болон жишиг төлбөрийн хэмжээг батлах тухай” 2023 оны А/04 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын жишиг хөтөлбөр, модулийг хавсралтаар баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, сургалтын жишиг хөтөлбөр, модулийг энэхүү жишиг хөтөлбөр, модулийн дагуу боловсруулж, аймгийн Засаг даргаар шийдвэрлүүлж, сургалт зохион байгуулсан талаарх тайлан мэдээг улирал тутам тайлагнаж ажиллахыг сургалт эрхлэх хуулийн этгээдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай)-д даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,  
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР



Аймгийн Засаг даргын 2023 оны 05  
дугаар сарын 23-ны өдрийн А/270...  
дугаар захирамжийн хавсралт

## СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨР, МОДУЛ

### Нэг. нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү хөтөлбөр, модулийн зорилго нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/04 “Журам болон жишиг хөтөлбөр батлах тухай” А/04 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын 2.2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж, зохицуулахад оршино.

1.2 Энэхүү хөтөлбөр, модуль нь Сogтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/04 “Журам болон жишиг хөтөлбөр батлах тухай” А/04 дүгээр тушаалд нийцсэн байна.

### Хоёр. Сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага, агуулга

2.1 Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг таниулах;

2.2 Үйлчлүүлэгчийг согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэх;л

2.3 Согтууруулах ундааны нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл;

2.4 Согтууруулах ундааны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл;

2.5 Насанд хүрээгүй, эсвэл согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үйлчлүүлэгчд согтууруулах ундаагаар үйлчлэхээс зайлсхийх арга барил;

### Гурав. Модуль-1 Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг таниулах агуулгын хүрээнд

**Хичээл-1** Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн төрөл, тавигдах нийтлэг шаардлага, тусгай зөвшөөрлийг олгох, хүчингүй болгох, сэргээх, түдгэлзүүлэх үндэслэл, журмын талаар мэдлэг олгох;

**Хичээл-2** Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох газар, өдөр, түүгээр үйлчлэхэд хориглох зүйл, цагийн хязгаар, эзэмшигчийн хариуцлагын талаар мэдлэг олгох;

**Хичээл-3** Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль болон холбогдох хууль тогтоомжид архидан согтуурахтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаар хэрхэн тусгасан, ногдуулах шийтгэлийн талаар мэдлэг олгох.



**Дөрөв. Модуль-2 Үйлчлүүлэгчийг согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэх агуулгын хүрээнд**

**Хичээл-1** Сургалтаар үйлчлүүлэгчийг согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйлчилгээний соёл, арга барилын талаарх олголтыг олгох.

**Тав. Модуль-3 Согтууруулах ундааны нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийн агуулгын хүрээнд**

Сургалтаар согтууруулах ундааны нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаарх дараах ойлголтыг олгоно.

**Хичээл-1** Согтууруулах ундааны нийгэмд үзүүлэх ерөнхий нөлөөлөл, нийгэмд үзүүлэх ерөнхий сөрөг үр дагавар.

**Зургаа. Модуль-4 Согтууруулах ундааны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл талаарх агуулгын хүрээнд**

**Хичээл-1** Архинд донтох эмгэгийн талаар;

**Хичээл-2** Хорт хавдар, элэгний хатуурал зэрэг архинаас үүдэлтэй өвчин, эмгэгийн талаар ерөнхий мэдлэг олгох;

**Хичээл-3** Архи нь хүний оюун ухаан, сэтгэл зүй, зан араншинд хэрхэн нөлөөлдөг талаарх ойлголт болон хүний бие согтрууруулах ундааг хэрхэн боловсруулдаг тухай.

**Долоо. Модуль-5 Насанд хүрээгүй, эсвэл согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үйлчлүүлэгчд согтууруулах ундаагаар үйлчлэхээс зайлсхийх арга барил агуулгын хүрээнд**

7.1 Сургалтаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн бусдад үйлчлэх үүрэг бүхий ажилтан нь үйлчлүүлэгчийн баримт бичгийг шалгах эрхтэй бөгөөд үйлчлүүлэгч 21 нас хүрээгүй гэх үндэслэл байгаа тохиолдолд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийн өмнө хуулиар зөвшөөрөгдсөн насанд хүрсэн эсэхийг шалгах зорилгоор үйлчлүүлэгчийн дараах баримт бичгийг биечлэн болон техник технологи ашиглан шалгах талаах дараах ойлголтыг олгоно.

- 7.1.1 Иргэний үнэмлэх;
- 7.1.2 Жолооны үнэмлэх;
- 7.1.3 Гадаад паспорт.

7.2 Сургалтын агуулгад энэ журмын хөтөлбөр модулын 7.1-д заасан ажилтан нь үйлчлүүлэгч баримт бичиггүй, эсхүл баримт бичгээ шалгуулахаас татгалзсан тохиолдолд түүнд согтууруулах ундаа худалдахгүй, эсхүл түүгээр үйлчлэхгүй.

7.3 Сургалтаар үйлчлүүлэгчид согтууруулах ундаагаар үйлчлэхээс татгалзах арга барилын талаар дараах ойлголтыг олгоно: Үүнд.



**Хичээл-1** Үйлчлүүлэгчид цаашид үйлчлэх боломжгүй гэдгээ эелдэг байдлаар ойлгуулах, согтууруулах ундааны үйлчилгээг зогсоох шийдвэр гаргахдаа тууштай байх, хамт ажиллаж байгаа хүмүүст тухайн хүнд согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх шийдвэр гаргасан тухайгаа мэдэгдэх;

Үйлчлүүлэгчтэй хамт явж байгаа хүмүүст мэдэгдэх, ус, ундаа, эсхүл хүнсний зүйл санал болгох;

7.3.6 Шаардлагатай тохиолдолд такси дуудаж өгөх зэргээр аюулгүй байдлыг нь хангах арга хэмжээ авах зэрэг.

### **Найм. Бусад**

8.1 Сургалт эрхлэн явуулах хуулийн этгээд нь Төрийн бус байгууллагын тухай хуульд заасан төрийн бус байгууллагад тавигдах ерөнхий шаардлагыг хангасан байх ба сургалт эрхлэн явуулах хүсэлт, энэхүү жишиг хөтөлбөр, модулын дагуу хөтөлбөрөө боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулна.

8.2 Сургалтын дээрх 5 агуулгыг нийт 4 цагт хуваан хөтөлбөрийг боловсруулж батлуулна.

\_\_\_оОо\_\_\_